

СЗХ 32
161

ШАРЫНГОЛ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

№ 01

20 14 ОНЫ 4. САРЫН 30 ӨДӨР



SHARYN GOL JSC

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59.60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2.3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагаас “Корпорейт” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

- а. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг батлах
- б. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсвийг батлах
- в. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг 2014 оны 3 сарын 05-ны өдөр байхаар тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2014 оны 2 дугаар сарын 23, санал авах хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөр тус тус тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг /хавсралт 1/-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдож хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг / хавсралт 2/-аар тус тус баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг Гүйцэтгэх захирал /Грам Чапман/, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал /Жимми Уайлд/, Санхүү эрхэлсэн захирал /Жеймс Флорес/ нарт даалгасугай.

34
163

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн дарга Б.Батмөнхийг томилсугай.

8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын дарга: Б.Батмөнх
Гишүүд: Д.Байлхүү – ТУЗ-ийн гишүүн
Жеймс Пассин – ТУЗ-ийн гишүүн
Л.Батсуурь – Нарийн бичгийн дарга
Б.Отгонзул – БХХОХ Захирал
Л.Эрхбаатар – ЗААЭ Дэд Захирал

9. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын дарга: Б.Батбаатар – ТУЗ-ийн гишүүн
Гишүүд: Д.Даянбилгүүн – ТУЗ-ийн гишүүн
Л.Оюундарь – Эдийн засагч

10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргаж зохих журмын дагуу хуралдуулахыг комисс /Б.Батмөнх/-д даалгасугай:

ДАРГА



Б.БАТМӨНХ


БАТЛАВ: ТУЗ-ийн дарга

Б.Батмөнх

Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахад
хийгдэх ажил, цаг хугацааны график

Хуулийн эцсийн хугацаа	Төлөвлөж буй хугацаа	Хийгдэх ажил	Бэлдэх материалууд
Санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор 2 сарын 20	2 сарын 18-ны 16 цаг	Ногдол ашиг тараах эсэх шийдвэр гарах /тогтоол гарна/	-Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар ногдол ашиг тараах эсэх талаар шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, бүртгэлийн өдрийг тогтоох
ТУЗ-ийн шийдвэрийг гарснаас ажлын 3 хоногийн дотор хүргэх	2 сарын 21	Ногдол ашгийн талаарх мэдээлэл хүргэх	-Ногдол ашиг хуваарилах тухай мэдэгдлийг хурлын материал, шийдвэрийн хамт, ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор СЗХ, МХБ-д хүргүүлэх
Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу 40-өөс доошгүй хоног 3 сарын 01	2 сарын 18	ХЭХ хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарах /тогтоол гарна/	-ТУЗ-ийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталсан байх 1. Компанийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт 2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан 3. ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулал, зардлын төсөв 4. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэр 5. Хурал хуралдуулах зар гаргах өдөр, бүртгэлийн өдөр, саналын хуудасны агуулга, загвар 6. Хурлын дарга, хуралд бэлтгэх комисс, тооллогын комисс томилох
ХЭХ хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор мэдээлэл хүргэх 3 сарын 04	2 сарын 21	ХЭХ хуралдуулах тов, хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг СЗХ, МХБ-д хүргүүлэх	-Уг шийдвэр бүхий мэдээлэлд; 1. Хурлын мэдэгдэл 2. Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр /тогтоол/ 3. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа 4. Хэвлэл мэдээлэлийн хэрэгслэлээр нийтэд мэдээлэх зарын загвар
ХЭХ-ыг хуралдуулах шийдвэр гарснаас хойш 5 хоног 3 сарын 06	2 сарын 23	ХЭХ-ын зар гаргах	-ХЭХ-ын зард зайлшгүй орсон байх мэдээлэл /МХБ-ийн сайт, өдөр тутамын 2-оос доошгүй сонин/ 1. Хурал хуралдуулах газар, өдөр, цаг

			<p>2. Бүртгэлийн өдөр</p> <p>3. Хурлын хэлэлцэх асуудлууд гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг</p> <p>4. Хурал хуралдуулах зар гаргах өдөр, журам</p> <p>5. Хурлын комиссын дарга, гишүүдийн утас, электрон хаяг, ажиллах цагийн хуваарь</p> <p>6. Шаардлагатай бусад мэдээлэл</p>
3 сарын 16	3 сарын 05	Бүртгэлийн өдөр /ХЭХ-ын зар гарснаас хойш 10 дахь өдөр/	
3 сарын 21	3 сарын 10	Зар давтан гаргах	-ХЭХ-ын зарыг гаргаснаас хойш 15 хоногийн дараа зарыг давтан гаргана
Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл холбогдох баримт бичгийг, анх зар гарсан өдрөөс хойш 5 хоногт багтаан брокерт хүргэнэ. 3 сарын 11	3 сарын 20	ХЭХ-ын баримт бичгийг брокер диллерийн компаниудад гэрээний дагуу хүргүүлэх	-ХЭХ-ын материалыг товхимол болгон ХЭ-дэд урьдчилан таниулах зорилгоор брокер диллерийн компаниудад хүргэж байрлуулна.
3 сарын 01	3 сарын 01-ээс өмнө	Санхүүгийн жилийн эцсийн тайлан, аудиторын дүгнэлтийг хүргүүлэх	-Санхүүгийн жилийн эцсийн тайланг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргаж аудиторын дүгнэлтийн хамт СЗХ, МХБ-д хүргүүлэх, өдөр тутмын сонинд мэдээлэх
ХЭХ хуралдах 4 сарын 30	4 сарын 30	ХЭХ хурал хуралдуулах	-Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сард багтаана.
5 сарын 31		ХЭ-ийн ээлжит хурлын материал, гаргасан шийдвэрийн хамт СЗХ, МХБ-д хүргүүлэх	

График хийсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  Л.Батсуурь

57
166


**Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлын
графикчилсан төлөвлөгөөний гүйцэтгэл**

2014.04.23

д/д	Графикчилсан төлөвлөгөөний агуулга	Гүйцэтгэл
1.	Ногдол ашиг тараах эсэх шийдвэр гаргах	- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014.02.18-ны өдрийн хурлаар хэлэлцэж ТУЗ-ийн хурлын 2 дугаар тогтоол гаргасан
2.	Ногдол ашгийн талаарх мэдээлэлийг СЗХ, МХБ-д хүргүүлэх	- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн, шийдвэр /хавсралт 7 хуудас/-ыг 2014.02.21-ний 44 дүгээр албан бичгээр СЗХ, МХБ-д хүргүүлсэн.
3.	ХЭХ хуралдуулах ТУЗ-ийн шийдвэр гаргах	- ХЭХ-ыг хуралдуулах шийдвэрийг 2014.02.18-нд буюу ХЭХ-аас 70 хоногийн өмнө гаргасан. - Хуралд хэлэлцэх асуудал, хурал хуралдуулах зар гаргах өдөр, бүртгэлийн өдөр, саналын хуудасны агуулга, загвар, хурлын дарга, хуралд бэлтгэх, тооллогын комисс зэргийг томилсон ТУЗ-ын шийдвэр тогтоол №05-ыг гаргасан.
4.	ХЭХ хуралдуулах тов, хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг СЗХ, МХБ-д хүргүүлэх	- Уг мэдээллийг СЗХ, МХБ-д 2014.02.21-ний 44-р албан бичгээр хүргүүлсэн. Мэдэгдэлд: ТУЗ-ийн шийдвэр, /тогтоол/, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийн жагсаалт, бэлэн болгох хугацаа, хэвлэлээр зарлах зарын загвар г.м
5.	ХЭХ-ын зар гаргах	- ХЭХ-ын зарыг 2014.02.22-ны “Өдрийн сонин” №044, 2014.02.23-ны “Өнөөдөр” сонин №042-г гаргаж МХБ-ийн сайтад тавьсан. ХЭХ хуралдуулах газар, өдөр, цаг, бүртгэлийн өдөр, хурлаар хэлэлцэх асуудал, танилцах газар, ажиллах цаг, зар гаргах өдөр, хурлын комиссын утас, электрон хаяг, шаардлагатай бусад мэдээлэлийг тавьсан.
6.	Бүртгэлийн өдөр /ХЭХ-ын зар гарснаас хойш 10 дахь өдөр/	- ХЭХ-ын зар гарснаас хойш 10 дахь өдөр буюу 2014.03.05-аар, “ҮЦТТХТ” ХХК-аар хувьцаа эзэмшигчдийн судалгааг гаргуулж тасалбар болгов.
7.	ХЭХ-ын зарыг давтан гаргах	- ХЭХ-ын зарыг гаргаснаас хойш 15 хоногийн дараа давтан зар гаргасан. Үүнд: “Өдрийн сонин” 2014.03.10-ны №058, “Өнөөдөр” сонин 2014.03.10-ны №056-д гаргасан.
8.	Санхүүгийн жилийн эцсийн тайлан, аудиторын дүгнэлтийг хэвлэлд нийтлүүлэх	- Санхүүгийн жилийн эцсийн тайлан /аудитлагдаагүй/-г 2014.02.12-ны №034-д нийтлүүлсэн. <i>“ӨДРИЙН СОНИН”</i>
9.	Санхүүгийн жилийн эцсийн тайлан, аудиторын дүгнэлтийг СЗХ, МХБ-д хүргүүлэх /сарын 01-ээс өмнө/	- Санхүүгийн жилийн эцсийн тайлан /аудитлагдаагүй/-г 2014.02.10-ны дугаар 38-аар СЗХ, МХБ-д хүргүүлсэн /СЗХ-ны албан шаардлага 2 сарын 10-ны дотор гэсэн/

58
167

10.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал бэлтгэж товхимол болгон компанийн хувьцаа буй БДК-уудад хүргүүлэх	- Компанийн ХЭХ-ын материалыг бэлтгэж монгол, англи хэл дээр товхимол болгон хэвлэж 2014.03.21-нээс компанийн хувьцаа байгаа БДК-уудад хүргүүлж хувьцаа эзэмшигчдэд танилцах бололцоог бүрдүүлсэн.
11.	Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах /эхний 4 сард/	- ХЭХ-ыг ТУЗ-ийн хурлаар төлөвлөсөн хугацаа буюу 2014.04.30-нд хуралдуулж байна.

Гүйцэтгэл гаргасан: ТУЗ-ийн н/б дарга  Л.Батсуурь

89
167

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН МЭДЭЭЛЭЛ

2014.04.30


Шарынгол

“Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон тооллогын комисс нь “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авч нэгтгэлээ. Үүнд:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хуралд нийт 10.231.389 ширхэг энгийн хувьцаанаас саналын эрхтэй 10.170.242 ширхэг энгийн хувьцааг төлөөлж 8.328.692 ширхэг энгийн хувьцаа буюу 81.9 хувь нь санал ирүүлсэн учир хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг хангалттай гэж тооллогын комисс үзэж хурлын даргад мэдээлж байна.
 - Тухайн хурлаар шийдвэрлэх асуудал тус бүрд нэг ширхэг хувьцаа нэг саналын эрхтэй байна.
 - Хэлэлцэж буй асуудал тус бүрт санал өгөх бөгөөд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэнэ.
 - Хуралд хэлэлцэх асуудлын 3 дугаарт бичигдсэн “Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах” асуудал нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцээд шийдвэр гарчихсан тул хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэл болгон танилцуулах юм.
 - Хурлаас гарах шийдвэрийг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ гэдгийг тайлбар болгож байна.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье

Тоологын комиссын дарга



Б.Батбаатар

70
169

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
хуралд хэлэлцэх асуудал

2014.04.30

Шарын гол

1. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
2. Компанийн ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсөв
3. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон танилцуулга

Хурлын дарга



Б.Батмөнх

41
130

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын дотоод журам**


2014.04.30

Шарын гол

1. “Шарын гол” ХК-ийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан /30 минут/
2. Компанийн ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулал, зардлын төсөв /10 минут/
3. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах /10 минут/
4. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал бодол /цаг тогтоохгүй/
5. Хурлаас гарах шийдвэрийг хэлэлцэж батлах /цаг тогтоохгүй/

Хурлыг 2 цагт багтааж дуусгана.

Хурлын дарга



Б.Батмөнх



SHARYN GOL JSC

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46.1-р зүйл, компанийн дүрмийн 12-р бүлгийн заалт болон ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Уурхайн уулын ажлын өрнөл, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл болон шинээр нээгдэх уурхайн хөрс хуулалтын коэффициент их байгаагаас гарах зардал өндөр, хөрөнгө оруулалтын хэмжээ өсч байгаа зэргээс шалтгаалан 2013 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /Б.Батмөнх/-д даалгасугай.



Б.БАТМӨНХ

64
182

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2014.04.30

дугаар 01

Улаанбаатар

**Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн
тайлан дүгнэлтийн тухай**

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцсэн компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн тайлан дүгнэлтийн асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал тоолсон дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн тайлан дүгнэлтэд санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн 8.325.875 ширхэг хувьцааны саналын 100 хувь нь зөвшөөрсөн санал өгснийг тогтоосугай.

Тооллогын комиссын дарга



Б.Батбаатар

45
113

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2014.04.30

дугаар 02

Улаанбаатар

**Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн
2014 оны зардлын төсөвийн тухай**

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцсэн “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны цалин урамшуулал болон зардлын төсөв”-ийн санал тоолсон дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны цалин урамшуулал, зардлын төсвийн талаар санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн 8.325.875 ширхэг хувьцааны саналын 8.325.678 ширхэг хувьцааны санал буюу 99.99 хувь нь зөвшөөрсөн санал өгснийг тогтоосугай.

Тооллогын комиссын дарга



Б.Батбаатар

86
184

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014.04.30

дугаар 02

Шарынгол

**Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2014 оны зардлын төсвийн тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын төсвийг / хавсралтаар / баталсугай.
2. Компанийн удирдлагын зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ

185

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014.04.30

дугаар 01

Шарынгол

**Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
ТУЗ-ийн ажлын тайлангийн тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 онд хийсэн ажлыг /хангалттай/ гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ

52
186



“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

Шарынгол” ХК-ийн ТУЗ-ийн 2014 оны зардлын төсөв

д/д	Зардлын төрөл	Нийт зардал м.төг
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	261,600.0
2	НДШ	34,008.0
3	Шуудан холбооны зардал	8,124.0
4	Бичиг хэргийн зардал	480.0
5	Сургалтын зардал	
6	Томилолтын зардал	52,000.0
7	Шатахуун	8,400.0
8	Зар сурталчилгаа	3,000.0
9	Хурлын зардал	2,000.0
10	Зочин хүлээн авалт	36,000.0
11	ТУЗ урамшууллын сан	60,000.0
12	Бусад	2,960.0
Нийт дүн		468,572.0

19265

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦААЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ИРҮҮЛСЭН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛЫН ТОВЧОО

д/д	Шийдвэрлэсэн асуудал	Санал				Батласан шийдвэр
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хувь	
1.	Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан	8.325.875			100	Тооллогын комиссын тогтоол дугаар 01
2.	Компанийн ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсөв	8.325.678	197		99.99	Тооллогын комиссын тогтоол дугаар 02
3.	Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон танилцуулга					Хурлын тэмдэглэл

Нийт санал ирүүлсэн саналын хуудас – 19 хувьцааны эрх 8.328.692

Үүнээс: Хүчинтэй саналын хуудас – 18 хувьцааны эрх 8.325.875

Хүчингүй саналын хуудас – 1 хувьцааны эрх 2.817

3 дугаар асуудлаар компани ТУЗ-ийн хурлын 2014 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоол гарсан болно.

Тооллогын комисс

1934



"Шарын гол" ХК-д

"БидиСЕК" ХК

Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

Залуучуудын өргөн чөлөө-27/1

Утас: 11-313108, Факс: 11-323411

www.bdsec.mn

Огноо 2014 оны 30 Дугаар #14/187

Хувьцаа эзэмшигчдийн хуралд
оролцох тухай

2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр болох "Шарын гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд "БидиСек" ХК-нийг /РД:2052482/ төлөөлөн тус компанийн мэргэжилтэн Б.Лхамдолгор /РД:ВЭ85082265/ оролцох, саналын хуудсыг хүргүүлэх, санал өгөх, мэдээлэл авах бүрэн эрхийг олгож байна.

ХҮНДЭТГЭСЭН,



Б.ЛХАГВАДОРЖ
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ

204

“Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн дарга гишүүд,
Нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага,
“Компанийн засаглал” сэдэвт сургалтанд
хамрагдсан тухай гэрчилгээний дугаар

№	Нэрс	Албан тушаал	Гэрчилгээний дугаар
1.	Б.Батмөнх	ТУЗ-ийн дарга	00043
2.	Б.Батбаатар	ТУЗ-ийн гишүүн	23-25-2009
3.	Ж.Батболд	ТУЗ-ийн гишүүн	00041
4.	Д.Байлхүү	ТУЗ-ийн гишүүн	
5.	Ц.Ганбат	ТУЗ-ийн гишүүн асан	0042
6.	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	0420027
7.	Жеймс Пассин	ТУЗ-ийн гишүүн	00050
8.	Жозеф Найэми	ТУЗ-ийн гишүүн	00049
9.	Грам Чапман	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	00051
10.	Кеннет Фаррел	ТУЗ-ийн гишүүн	
11.	Л.Батсуурь	ТУЗ-ийн н/б дарга	00045
12.	Б.Отгонзул	БХХОХ Захирал	00044
13.	С.Насанбат	Гүйцэтгэх захирал асан	00046